ЭВТ ЧУЛУУ ХХК

БЕТОН ЗУУРМАГ, БАРИЛГЫН МАТЕРИАЛ

# УЛААНБААТАР ХОТЫН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 32-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ БУЙ “ЭВТ ЧУЛУУ” ХХК ИЙН БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2025 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

ХЯНАСАН:
“ЭВТ ЧУЛУУ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

.............................. Г.БАЯРЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

.............................. О.САРАНГОО

УЛААНБААТАР
2025

**ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**

**1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ... 4**
1.1. Төслийн нэр ... 4
1.2. Төсөл хэрэгжүүлэгч ... 4
1.3. Төслийн хүчин чадал ... 4
1.4. Төслийн байршил ... 4
1.5. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил ... 6
**2. ТӨСЛИЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ ... 7**
2.1. Төсөл хэрэгжих талбайн газрын гадаргын эвдрэл, өөрчлөлт ... 8
**3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ ... 9**
3.1. Төсөл хэрэгжих үеийн болзошгүй нөлөөлөл ... 9
**4. 2025 ОНЫ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 11**
4.1. Байгаль хамгаалах төлөвлөгөө ... 11
4.2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ... 11
**5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 13**
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт баталгаажилт ... 15
5.1.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт... ... 15
5.1.2. Гадаргын болон газрын доорх ус нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ ... 16
5.1.3. Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ ... 17
**6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 19**
6.1. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт, тарималжуулалтын ажлын биелэлт ... 20
**7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 23**
**8. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 26**
**9. УДИРДЛАГА-ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 27**
**10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ... 38**
10.1. Хөрсөн бүрхэвчийн хяналт, шинжилгээ ... 39
10.2. Усан орчны хяналт шинжилгээ ... 39
**11. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ ... 44**
**12. ДҮГНЭЛТ ... 45**

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Болзошгүй сөрөг нөлөөлөл ба эх үүсвэр....9
Хүснэгт 2. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүн-1....39
Хүснэгт 3. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүн-2....39
Хүснэгт 4. Хүснэгт 6. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүн-3....39
Хүснэгт 6. Усны лабораторийн задлан шинжилгээний үр дүн ....39
Хүснэгт 7. Усны лабораторийн задлан шинжилгээний үр дүн ....41
Хүснэгт 8. Усны лабораторийн задлан шинжилгээний үр дүн ....42

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил....4
Зураг 2. Байрзүйн зураг....5
Зураг 3. Төслийн талбайн орчин....6
Зураг 4. Төслийн физик газарзүйн мужлалт....7
Зураг 5. Үйлдвэрийн хашаан доторх газрын гадаргын төлөв байдал....8
Зураг 6. Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлсөн баримт....15
Зураг 7. Миксерийн дугуйг угааж замын хөдөлгөөнд оролцуулж буй байдал....16
Зураг 8. Мананцар үүсгэгч байршуулсан байдал....16
Зураг 9. Гүний худагт тоолуур суурилуулсан байдал....17
Зураг 10. Усны тоолуурын баталгаажуулсан гэрчилгээ....17
Зураг 11. Саарал ус боловсруулах төхөөрөмж....17
Зураг 12. Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-тэй хийсэн 2025.02.14-ны өдрийн №24/27 дугаар бүхий хог, хаягдал хаях гэрээ....18
Зураг 13. Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилан ялгах хогийн савны харагдах байдал....18
Зураг 14. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт, тарималжуулалтын ажил хийсэн байдал ....20
Зураг 15. Тарималжуулалт ажил хийсэн байршил....21
Зураг 16. Ногоон байгууламж тарималжуулалтын ажлын өмнө....21
Зураг 17. Ногоон байгууламж тарималжуулалтын ажил хийж гүйцэтгэж дууссан байдал ....22
Зураг 18. Хөрөнгө гаргасан аж ахуйн нэгжийн нэрс....22
Зураг 19. Баянзүрх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах улсын нэгдсэн 2-р эмнэлгийн хажуу талын нийтийн эзэмшлийн талбайн бичил цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж, зүлэгжүүлэн тохижуулах ажлын тайлан....22
Зураг 20. Хог, хаягдал хаях, зайлуулах гэрээ....24
Зураг 21. Аюултай хог хаягдал хүлээн авч, тээвэрлэх гэрээ....24
Зураг 22. Хог хаягдлыг ангилан ангилж ялгах хогийн сав....25
Зураг 23. Улаанбаатар ариутгал” ХХК-р Халдваргүйтгэл, ахуйн хортон шавж, мэрэгчийн тандалт, устгалын ажлын хуудас....25
Зураг 24. Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан байдал ....29
Зураг 25. Ажил оргогчийн хөдөлмөрийнх аюулгүй байдал эрүүл ахуйн 8 болон 12 цагийн сургалтын гэрчилгээ, сургалтад хамрагдсан ажилчдын бүртгэлийн хуудас....30
Зураг 26. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл худалдан авах гэрээ....30
Зураг 27. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл....31
Зураг 28. Хөдөлмөрийн аюулгүй байдал болон ажлын байран дахь үйлдвэрийн ажлын аюулгүй ажиллагааны самбар....31

Зураг 29. Үйлдвэрийн талбайд байршуулсан галын сараалж болон галын хор..............32
Зураг 30. Галын аюулгүй байдлаас сэргийлсэн самбар, галын булан ............................32
Зураг 31. Галын аюулгүй байдлын дүгнэлт.......................................................................32
Зураг 32. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа..................................................................33
Зураг 33. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө.........................................................................33
Зураг 34. Газрын төлбөр тооцоо нийлсэн акт болон газрын төлбөр төлсөн баримт.......34
Зураг 35. Усны төлбөр төлсөн баримт ................................................................................34
Зураг 36.  Зам ашигласны төлбөр төлсөн баримт .............................................................35
Зураг 37. Цахилгааны төлбөр төлсөн баримт.....................................................................35
Зураг 38. 2025 оны ус ашиглах гэрээг байгуулахаар усны газрын https://ewater.mn/ цахим системд илээсэн байдал........................................................................................................35
Зураг 39. 2024 оны ус ашиглах гэрээ ..................................................................................36
Зураг 40. Ажлын байранд эмийн сан болон бусад анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх хэрэгслийг бэлэн байлгасан байдал .....................................................................36
Зураг 41. Нийгмийн хариуцлагын хүрээнд 2025 онд БЗД-ийн 92-р сургуулийн "3-а" ангид ухаалаг самбар болон ширээ сандлыг шинэчлэн тохижуулсан байдал ..........................37
Зураг 42. Зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах жишиг сургалтын үеийн зураг болон оролцсон аж ахуйн нэгжүүд .......................................................................................37

## ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Хог хаягдал хаях гэрээ.....................................................................................46
Хавсралт 2. Хог хаягдал хаях 24/34 тоот гэрээ ..................................................................50
Хавсралт 3. Ус ашиглах гэрээ...............................................................................................51
Хавсралт 4. Ажил оргогчийн хөдөлмөрийнх аюулгүй байдал эрүүл ахуйн 8 болон 12 цагийн сургалтын гэрчилгээ, сургалтад хамрагдсан ажилчдын бүртгэлийн хуудас.......54
Хавсралт 5. Баянзүрх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах улсын нэгдсэн 2-р эмнэлгийн хажуу талын нийтийн эзэмшлийн талбайн бичил цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж, зүлэгжүүлэн тохижуулах ажлын тайлан...............................................................62
Хавсралт 6. Аюултай хог хаягдал хүлээн авч, тээвэрлэх гэрээ .........................................66
Хавсралт 7. Галын дүгнэлт....................................................................................................69
Хавсралт 8. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл худалдан авах гэрээ ....70
Хавсралт 9. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа...............................................................73
Хавсралт 10. Улаанбаатар ариутгал” ХХК-р Халдваргүйтгэл, ахуйн хортон шавж, мэрэгчийн тандалт, устгалын ажлын хуудас.......................................................................74
Хавсралт 11. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө....................................................................75
Хавсралт 12. Газрын төлбөр төлсөн баримт.........................................................................76
Хавсралт 13. Усны төлбөр төлсөн баримт............................................................................77
Хавсралт 14. Автотээрэв, өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлсөн баримт.............78
Хавсралт 15. Зам ашигтайяа төлбөр төлсөн баримт............................................................79
Хавсралт 16. Цахилгааны төлбөр төлсөн баримт ...............................................................80
Хавсралт 17. Усны тоолуурын баталгаажуулсан гэрчилгээ ...............................................82
Хавсралт 17. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний хариу ..................................83

# 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Төслийн нэр

“Бетон зуурмагийн үйлдвэр” төсөл

## 1.2. Төсөл хэрэгжүүлэгч

| “Эвт чулуу ” ХХК | |
|---|---|
| **Улсын бүртгэлийн дугаар** | 9011027118 |
| **Регистрийн дугаар** | 5053986 |
| **Холбоо барих утас** | 99770722 |

## 1.3. Төслийн хүчин чадал

Бетон зуурмагийн үйлдвэр нь цагт 60 м3, өдөрт 500 м3, сард 12500 м3, жилд 75000 м3 бетон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай. Нийт 31 ажиллагсадтай, 1 ээлжээр ажилладаг. Бетоны хольцыг технологийн дагуу үйлдвэрлэж, зориулалтын авто-бетон холигчоор тээвэрлэн, барилгын талбайд хүргэх ба авто машин дээр суурилуулсан бетон шахуурга ба суурин шахуургаар барилгын давхар, талбайн аль ч хэсэгт хуваарилан түгээж, тараах үйлчилгээг үзүүлнэ.

## 1.4. Төслийн байршил

“Эвт чулуу” ХХК ийн Бетон зуурмагийн үйлдвэр нь Нийслэлийн Баянзүрх дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт байрлана / хуучинаар 22 хороо/ . Төсөл нь нийт 1.2 га талбайд хэрэгжинэ.




Зураг 1. Төслийн талбайн байршил

ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРЗҮЙН ЗУРАГ




Зураг 2. Байрзүйн зураг







Зураг 3. Төслийн талбайн орчин

### 1.5. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил

Цахилгаан хангамж: Цахилгаан эрчим хүчийг ойролцоох эрчим хүчний төвлөрсөн шугамаас хангадаг.

Дулаан хангамж: Төсөл нь улирлын чанартай ажиллаж, зөвхөн дулааны улиралд үйл ажиллагаа явуулах тул хүйтний улирлын дулаан хангамж, халаалт шаардлагагүй.

Усан хангамж: Төслийн талбай дахь гүний худгаас ундны усны хэрэгцээг хангана.

Харилцаа холбоо: Холбоо мэдээллийн хувьд бүх үүрэн телефон холбоо ашиглах боломжтой.

Зам харилцаа: Цагаан давааны өвөр хажууд байрладаг, Цагаан давааны засмал замаар 3 орчим км явж хүрнэ.

## 2. ТӨСЛИЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн уулсын баруун өмнөд шувтрах үзүүрт Богдхан уулын ард, Туул голын өргөн хөндий ба түүний цутгал голуудаар хэрчигдсэн хэсэгт оршино. Туулын дэнж хотын зүүн хэсэгт нарийн 2.5-3.0 км орчим өргөн, баруун тийш болох тутам өргөсөн хотын баруун талд 5.0-5.5 км орчим өргөн болох ба ерөнхийдөө зүүнээсээ баруун тийшлэх тусмаа намсана. Хотын эргэн тойронд Богдхан уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй уулс хүрээлнэ.

Улаанбаатар хотын нутаг нь гадаргын тогтцын хувьд Хэнтийн нурууны баруун урд шувтарга үзүүрийн буюу Туул голын сав дагуух хавтгайдуу бөмбөгөр оройтой, эгцэвтэр хажуу бүхий дундаж өндөр, нам уулс, тэдгээрээс зүг бүр тийш эх аван урсах голуудын хөндий, дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаар дүүргэгдсэн томоохон хотос зэрэг хотгор гүдгэрийн олон хослолоос тогтоно.  Нам, дунд өндөрлөгтэй уулын хажуу, бэл, хормой ба Улиастай голын хөндийн хэсэгт байрлана.







Зураг 4. Төслийн физик газарзүйн мужлалт

## 2.1. Төсөл хэрэгжих талбайн газрын гадаргын эвдрэл, өөрчлөлт

Төсөл хэрэгжих талбай орчим нь нийслэл хотын хүн ам суурьшсан бүсэд байрлалтай учир ойр орчмын газрын гадарга, хөрс нь техноген нөлөөлөлд нэлээд өртсөн байна. Төслийн талбайгаас 2 км орчимд Цагаан давааны хогийн цэг, 100 орчим метрийн зайд оршуулгын газар байрладаг.

Бетон зуурмагийн үйлдвэрийн төслийн эдэлбэр газрын хэмжээ 1.2 га бөгөөд талбайг хатуу хатуужилтай болгосон байна.




Зураг 5. Үйлдвэрийн хашаан доторх газрын гадаргын төлөв байдал

Төслийн талбайд барилга байгууламжийн талбайн хэмжээгээр хөрс, ургамлан бүрхэвч устсан. Тээврийн хөдөлгөөнөөр үүсэх тоосжилт орчны ургамалжилтад дам нөлөөлж болзошгүй.

Нөлөөллийн эрчим, цар хүрээ нь цаашид хэрэгжүүлэх арга хэмжээтэй шууд холбогдох бөгөөд орчны тохижилтыг сайжруулан, хатуу хучилттай болгоогүй хэсгийг сайжруулснаар обьектуудын доор дарагдах талбайгаас бусад талбайн хөрс, газрын гадарга нөлөөлөлд бага өртөх нөхцөл бүрдэнэ.

# 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг өмнөх хэсэгт авч үзсэнийг нэгтгэвэл 24 үзүүлэлтээр нөлөөллийн эрчмийг тодорхойлсноос байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн нөлөөллийн 41.6% нь бага, 50.0% нь дунд, 8,3% нөлөөгүй байна. Агаарын чанар, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчим байгаль орчны бусад бүрдэл хэсгүүдээс их байна.

## 3.1. Төсөл хэрэгжих үеийн болзошгүй нөлөөлөл

“Эвт чулуу” ХХК-ийн “Бетон зуурмагийн үйлдвэр” төслийг хэрэгжүүлэхэд хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлсон үр дүнд үндэслэн нөлөөллийн эх үүсвэр, шинж чанарыг тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлэв. Өмнө нь хийгдсэн болзошгүй нөлөөллийн судалгааны дүнгээс үзвэл тус үйлдвэр, агуулахын төслөөс байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь:

Хүснэгт 1. Болзошгүй сөрөг нөлөөлөл ба эх үүсвэр

| № | Нөлөөлөл | Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа) | Нөлөөллийн шинж чанар |
|---|---|---|---|
| *Агаар орчин* | | | |
| 1 | Тоосжилт ($PM_{2.5}$, $PM_{10}$) | - Ажилчдын хөл хөдөлгөөн<br>- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн<br>- Түүхий эд хүлээн авах, хадгалах талбай | - Улирлын чанартай.<br>- Тархах хүрээ хязгаарлагдмал.<br>- Салхины хурд бриксийн хурдаас давах, агаарын температур их үед үүснэ.<br>- Ширхэгийн хэмжээ, чийгшлийн хэмжээнээс ялгаралт хамаарна. |
| 2 | Хийн хаягдал (Утаа, Угаар, SO, NO, CO) | - Тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгүүр | - Улирлын чанартай.<br>- Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал. |
| *Усан орчин* | | | |
| 3 | Усны нөөцийн хомсдол | - Технологийн усны хэрэглээ<br>- Унд ахуйн усны хэрэглээ | - Одоогийн усны хэрэглээ боломжит усны нөөц хүрэлцээтэй байна.<br>- Шууд биш дам нөлөөлөл |
| 4 | Хатуу болон шингэн хаягдал | - Ахуйн хог хаягдал<br>- Шатах тослох материалын хаягдал<br>- Миксерт наалдсан бетон зуурмагийг угаах | - Газрын доорх ус бохирдолд өртөгдөж болзошгүй<br>- Удаан сарнина. |
| *Хөрсөн бүрхэвч* | | | |
| 5 | Элэгдэл, эвдрэл | - хүний хөл хөдөлгөөнд өртөж хөрс дагтарших, талхлагдах<br>- Үйлдвэрийн дотоод зам талбайг зөв зохион байгуулах | - Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөлт орох.<br>- Тархалтын хүрээ хязгаарлагдмал.<br>- Ямар нэг хэмжээгээр нөхөн сэргээх боломжтой. |
| 6 | Бохирдол | - Ахуйн хог хаягдал<br>- Шингэн хаягдал<br>- Шатах тослох материалын асгаралт | - Тархах хүрээ хязгаарлагдмал.<br>- Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана. |
| *Ургамлан бүрхэвч* | | | |
| 7 | Ургамлан нөмрөг талхлагдах | - Ашиглалтын талбай, барилга байгууламжийн орчимд | - Хэмжээ хязгаарлагдмал<br>- Ногоон байгууламж, тарималжуулалт хийснээр нөхөн сэргээх боломжтой. |
| *Амьтан* | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | Дайжих | - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн<br>- Дуу чимээ | - Тухайн орчинд амьдрах боломжгүй болж дайжих |
| 9 | Хордох | - Хог хаягдал<br>- Шатах тослох материалын асгаралт | - Тархалтын хүрээ хязгаарлагдмал<br>- Хөрсөн дэх бичил биетэн, шавж хорхой үрэгдэх. |
| *Нийгэм-эдийн засгийн орчин* | | | |
| 10 | Үйл ажиллагаа | - Чанарын шаардлага хангасан бетон зуурмагийг үйлдвэрлэх | - Барилгын салбарыг түүхий эдээр хангах |
| 11 | Үндсэн хөрөнгө | - Татварын эх үүсвэр | - Улсын төсөвт хувь нэмэр оруулна. |
| 12 | Шинэ ажиллагсад | - Ажлын байр бий болно. | - Орон нутгийн иргэд орлогын тогтмол эх үүсвэртэй болно. |

Магадлан жагсаах аргаар нөлөөлөл тодорхойлсон дүнгээс үзэхэд тус төсөл нь байгаль орчинд нөлөөлөх байдлаараа "дунд" нөлөөлөлтэй байна. Төслийн гол анхаарах асуудал нь хатуу болон шингэн хаягдлыг байгаль орчинд бохирдол үүсгэхгүйгээр зайлуулах, гадаад, дотоод тээврийн замыг тодорхой байлгаж, олон салаа зам бий болгохгүй байх, үржил шимт хөрсний овоолгыг технологийн дагуу байршуулж, ургамалжуулах, зам талбайн тоосжилтыг дарах, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, тухай бүрд нь нөхөн сэргээлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ажилчдын хөдөлмөр хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарч стандарт шаардлагыг дагаж мөрдөх зэрэг асуудал байна.

# 4. 2025 ОНЫ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Эвт чулуу” ХХК-ийн “Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл болон эрсдэлийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд төслийн үйл ажиллагаанд технологийн болон байгаль орчны дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үүс ч болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Эдгээр зөвлөмжийг авч хэрэгжүүлэхдээ энэхүү байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хууль эрх зүйн бүлэгт орсон хууль, дүрэм журам, стандарт болон Олон улсын конвецийн холбогдох заалтыг мөрдлөг болгон ажиллах хэрэгтэй.

## 4.1. Байгаль хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Эвт чулуу” ХХК-ийн”-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах баримт бичиг юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОУАӨЯ-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудтай уялдуулан боловсруулсан ба тэдгээрийн хэрэгжилтийг 5 жилийн хугацаанд буюу 2024 оноос 2028 оны хугацаанд төлөвлөв. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй. БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 11 сарын 1-ний дотор БОУАӨЯ-нд ирүүлж, мөн орон нутгийн засаг захиргааны байгууллага, хорооны иргэдэд танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

## 4.2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Эвт чулуу” ХХК-ийн хэрэгжүүлж буй “ийн “Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

***Агаар орчин***

ОХШХ-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж, дүгнэлт гаргуулж байх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. Хийн бохирдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амрагч, ажилчид, нутгийн оршин

суугчдын ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой буюу төлөвлөлтийн холбогдох үндсэн шалгуурууд агаарт хаяж буй бохирдуулагчдад тавигдах ёстой.

***Усны чанар***

Усны чанарын шинжилгээг төсөл хэрэгжих хугацаанд хийлгэх хяналт шинжилгээг графикт хугацаанд нь шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан, бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран түүнийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

***Хөрсөн бүрхэвч***

Хөрсний бохирдлын түвшинг дотоодын магадлан итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтоосон сорьц авах цэгүүд дээр үргэлжлүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.

**Ургамлан нөмрөг**

Барилгын ажлын үед эвдрэлд орсон талбайн нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, ургамлан нөмрөгийн мониторинг судалгааг төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.

**Амьтны судалгаа**

Ан амьтныг судлах, хамгаалах, хяналт тавих талаар амьтан судлаачидтай хамтран ажиллах, төслийн талбайн орчимд тохиолдох ховор, нэн ховор болон экологийн ач холбогдол бүхий амьтдын бүртгэл, фото зураг, холбогдох мэдээллийг цуглуулж, мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлэх мөн ажилчдад танилцуулах, тэдгээрийг хамгаалах, too толгойг нэмэгдүүлэх арга хэмжээг орон нутгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нийт зардал (.төг) | БИЕЛЭЛТ |
|---|---|---|---|---|---|
| **Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ** | | | | | |
| Тоосжилт үүсэх, хөрсөн бүрхэвч бохирдох, элэгдэх эвдрэх | Тээврийн хэрэгсэлд оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийж байх | Агаарын чанар | ш/удаа | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан. | Үйлдвэрт одоогийн байдлаар нийт 19 ширхэг машин ашиглаж байгаа бөгөөд. Ашиглаж буй тээврийн хэрэгслүүдэд жил бүр оношилгоонд хамруулан засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэж байна. |
| Хийн хаягдал, тоосжилт | Миксерийн дугуйг угааж замын хөдөлгөөнд оролцох | Агаарын чанар | Тогтмол | 10,000,000 | Төслийн үйл ажиллагаанаас гарч буй саарал усыг дахин ашиглах зорилготойгоор миксерийн дугуй болон доод эд ангийн тоос шороог цэвэрлэн угааж замын хөдөлгөөнд оролцуулах ажлыг тогтмол хийж гүйцэтгэж байна. |
| Тоосжилт үүсэх | Үйлдвэрийн талбайд тоосжилт үүсэхээс сэргийлэн манангцар үүсгэгч байршуулах | Агаарын чанар | Тогтмол | 20,000,000 | Үлдвэрийн гол хаалга миксер гарах хэсэг болон Үйлдвэрийн оффис руу орох зам болон бусад шаардагтай тоосжилт үүсэж болзошгүй хэсгүүдэд манангцар үүсгэгч тавьж тогтмол ажиллуулж байна. |
| **Гадаргын болон газрын доорх ус нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ** | | | | | |
| Ус ашиглалт | Төсөл хэрэгжүүлэгч нь ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журмыг мөрдөж тус журмын дагуу тоолуур суурилуулах. Гүний худаг болон цэвэр бохир усны оролт гаралт бүр т усны тоолуур суурилуулж баталгаажуулах шаардлагатай | Усны нөөц хэмнэх | Иж бүрэн | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан. | Төслийн талбайд байрлах гүний худгийг тоолууржуулсан болно. Усны тоолуурын баталгаажуулсан гэрчилгээг хавсралтаар хавсаргав. |
| Ус хэмнэлттэй ашиглах | Хаягдал усыг дахин шаглах /саарал ус ашиглах төхөөрөмж/ | | | 27,000,000 | Тээвэрлэгч машины угаасан саарал усыг тунгааж дахин ашиглан усны хаягдал 99% бууруулан ажиллаж байна. |
| **Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ** | | | | | |
| Хөрс элэгдэх, ургамлан нөмрөг талхлагдах Олон салаа зам гарах | Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх | Хөрс хамгаалал | Удирдлага зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой | | Миксерүүд болон бусад үйлдвэр ашигладаг машин техникүүдийг ажилд гарахаас өмнө техникийн үзлэг шалгалт хийн гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гарахгүй байх арга хэмжээг ХАБА тогтмол хянаж ажилдаг. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ургамлан нөмрөг талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох | Эзэмшил газрын хог хаягдлыг цэвэрлэх, эвдэрсэн хөрсийг засаж тэгшлэх, | Хөрс, ургамлан нөмрөг | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан. | Үйлдвэрийн эдэлбэр газрыг тогтмол цэвэрлэх болон хатуу хучилт бүхий талбайг хагарч цуурах, эвдрэх зэргээс сэргийлэх, эвдэрсэн тохиолдолд зас ч янзлах ажлыг тогтмол хийж гүйцэтгэж байна. Хог хаягдлын цэгт түр хуримтлуулан “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-тэй хийсэн 2025.02.14-ны өдрийн №24/27 дугаар бүхий хог, хаягдал хаях гэрээний дагуу зайлуулж байна. |
| Хөрс элэгдэх, ургамлан нөмрөг талхлагдах | Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж, хураан хуримтлуулах зориулалтын цэгт хогийн сав байршуулах | Хог хаягдлын менежмент | - | Үйлдвэрийн талбайд хог хаягдлыг ангилан ялгах хогийн ялган ангилж, хураан хуримтлуулах зориулалтын цэгт хог хаягдлын түр хуримтлуулж байна. |
| **Нийт** | | | **57,000,000** | |

## 5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт баталгаажилт

### 5.1.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

**Тээврийн хэрэгсэлд оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийж байх:** Үйлдвэрт одоогийн байдлаар нийт 19 ширхэг миксер, машин техникүүд ашиглаж байгаа бөгөөд ашиглаж буй тээврийн хэрэгслүүдэд жил бүр техникийн хяналтын үзлэгт хамруулан авто тээврийн хэрэгслийн ерөнхий байдал, иж бүрдэл, хөдөлгүүр, хүч дамжуулах анги, тоормосны систем, жолооны механизм, гэрэл дохио, явах анги, экологи болон эргономикийн үзүүлэлтүүд стандартын шаардлага хангаж байгаа байдалд зэрэгт техникийн дүгнэлтийг жил бүр гаргуулан ажиллаж байна.


TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Огноо: 2025.10.13

Шилжүүлгийн мэдээлэл
Журналын № : 941700546587

Системийн огноо: 2025.10.13 10:43:21

Нэр : ЭВТЧУЛУУ ХХК

| | | | Дүн | | Ханш |
|---|---|---|---|---|---|
| Илгээгч | Дансны дугаар: 426088088 | Нэр: ЭВТЧУЛУУ ХХК | 48,000.00 | MNT | 1 |
| Хүлээн авагч | Банкны дугаар: 04<br>Дансны дугаар: 4904962560040077 | Банкны нэр: Худалдаа Хөгжлийн Банк<br>Нэр: МОСТ МОНИ ӨГЛӨГ | 48,000.00 | MNT | 1 |
| Гүйлгээний утга: MM: EB -1250218468163-Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар-Баянз | | | | | |

Танд баярлалаа

Дансны тодорхойлолтыг QR код болон дараах холбоосоор хандаж баталгаажуулна уу.
https://www.etdbm.mn/verify.php
Баталгаажуулах код: 4FCCFEEA36ED511E

Зураг 6. Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлсөн баримт

**Миксерийн дугуйг угааж замын хөдөлгөөнд оролцох:** Төслийн үйл ажиллагаанаас гарч буй саарал усыг дахин ашиглах зорилготойгоор миксерийн дугуй болон доод эд ангийн тоос шороог цэвэрлэн угааж замын хөдөлгөөнд оролцуулах ажлыг тогтмол хийж гүйцэтгэж байна.










Зураг 7. Миксерийн дугуйг угааж замын хөдөлгөөнд оролцуулж буй байдал

**Үйлдвэрийн талбайд тоосжилт үүсэхээс сэргийлэн мананцар үүсгэгч байршуулах:** Үлдвэрийн гол хаалга миксер гарах хэсэг болон үйлдвэрийн оффис руу орох зам болон бусад шаардгахтай тоосжилт үүсэх эрсдэлтэй хэсгүүдэд мананцар үүсгэгч тавьж тогтмол ажиллуулж байна.




Зураг 8. Мананцар үүсгэгч байршуулсан байдал

### 5.1.2. Гадаргын болон газрын доорх ус нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

**Гүний худагт тоолуур суурилуулж баталгаажуулах:** Төслийн талбайд байрлах гүний худгийг тоолууржуулсан бөгөөд 2025 оны усны тоолуурын баталгаажуулалтын № ЭҮ 068985 дугаар бүхий гэрчилгээг авсан болно.



Зураг 9. Гүний худагт тоолуур суурилуулсан байдал



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ ЭУ 068985

..........................................................................-д
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа LXSG ........ загварын 6.3 м³/ц хэмжих хязгаартай, 25 мм-ийн голчтой № 2209099564 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 019 лацаар битүүмжилж
(доогуур зурах)

2025 оны 03 -р сарын 24 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 0001 м³

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2026 оны 03 -р сарын 24 -ны өдөр

Зураг 10. Усны тоолуурын баталгаажуулсан гэрчилгээ

**Хаягдал усыг дахин шаглах:** Тээвэрлэгч машины угаасан саарал усыг тунгааж дахин ашиглан усны хаягдлыг 99% бууруулсан бөгөөд саарал ус боловсруулах төхөөрөмжөөс гарсан саарал усыг дахин ашиглах зорилгоор миксерийн дугуйг угааж замын хөдөлгөөнд оролцуулж агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл болон усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан ажиллаж байна.




Зураг 11. Саарал ус боловсруулах төхөөрөмж

### 5.1.3. Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

**Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх:** Миксерүүд болон бусад үйлдвэр ашигладаг машин техникүүдийг ажилд гарахаас өмнө техникийн үзлэг шалгалт хийн гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гарахгүй байх арга хэмжээг ХАБА тогтмол хянаж ажиллаж байна.

**Эзэмшил газрын хог хаягдлыг цэвэрлэх, эвдэрсэн хөрсийг засаж тэгшлэх:** Үйлдвэрийн эдэлбэр газрыг тогтмол цэвэрлэх болон хатуу хучилт бүхий талбайг хагарч цуурах, эвдрэх зэргээс сэргийлэх, эвдэрсэн тохиолдолд зас ч янзлах ажлыг тогтмол хийж гүйцэтгэдэг бөгөөд үйлдвэрээс гарах хог хаягдлыг хог хаягдлын цэгт түр хуримтлуулан “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-тэй хийсэн 2025.02.14-ны өдрийн №24/27 дугаар бүхий хог, хаягдал хаях гэрээний дагуу зайлуулж байна.



**ХОГ, ХАЯГДАЛ ХАЯХ 24/34 ТООТ ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ГЭРЭЭ**

№ 24/27

2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр | Улаанбаатар хот

Нэг талаас "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ /цаашид "А" гэх/, нөгөө талаас "Эвт чулуу" ХХК РД:5053986 /цаашид "Б" гэх/ түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Амгаланбат /цаашид "Б" гэх/ нар харилцан тохиролцож, А болон Б нарын хооронд /цаашид хамтад нь Талууд гэх/ 2024 оны 03 дугээр сарын 04-ний өдөр байгуулсан 24/23 тоот "Хог хаягдал хаях гэрээ" /цаашид Үндсэн гэрээ гэх/-ний 6 дугаар зүйлийн 6.1 дахь хэсэг болон НИТХТ-ийн 2016 оны 14 дүгээр тогтоолоор баталсан Хот тохижилтын газрын дүрэм, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 24/27 дугаар тогтоолоор батлагдсан "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" тогтоолыг тус тус үндэслэн талууд харилцан тохиролцож энэхүү нэмэлт гэрээг байгуулав.

**Нэг.** Энэхүү нэмэлт гэрээнд 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан автомашин автомашинууд дээр хийсэн хог хаягдал хаях 24/23 тоот гэрээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүргэлт сунгав.

Хоёр.Үндсэн гэрээний 2 дугаар зүйлийн 2.1 дахь хэсэгт заасан нэг тонн хог хаягдлын үнэлгээ **6364 /зургаан мянга гурван зуун жаран дөрөв/** төгрөг бөгөөд НӨАТ шингэсэн үнэ болгож нэмэлт өөрчлөлт оруулав.

**Гурав.** Энэхүү нэмэлт гэрээ нь Үндсэн гэрээний салшгүй хэсэг болно. Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй бусад бүх харилцааг Үндсэн гэрээгээр зохицуулна.

**Дөрөв.** Энэхүү нэмэлт гэрээнд талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно. Энэхүү нэмэлт гэрээг хууль эрх зүйн хүрээнд адил хүчинтэй 3 хувь үйлдэв.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| А талыг төлөөлж: | Б талыг төлөөлж: |
|---|---|
| "ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Б.МӨНХЦЭЦЭГ | "ЭВТ ЧУЛУУ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.АМГАЛАНБАТ |
| ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ОЧИРОО | |
| ТООЦООНЫ НЯГТЛАН БОДОГЧ Ж.ДААРИЙМАА | |
| Хаяг: Баянзүрх дүүргийн 1 хороо, Залуусын гудамж, Сансар тунель дээрх өөрийн байр | Хаяг: Баянзүрх дүүргийн 41-р хороо, 63В-р байр, 301 тоот |
| Утас: 11- 453501 | Утас: 77168383, 94293993 |

Зураг 12. Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-тэй хийсэн 2025.02.14-ны өдрийн №24/27 дугаар бүхий хог, хаягдал хаях гэрээ

**Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж, хураан хуримтлуулах зориулалтын цэгт хогийн сав байршуулах:** Үйлдвэрийн талбайд хог хаягдлыг ангилан ялгах хогийн ялган ангилж, хураан хуримтлуулах зориулалтын цэгт хог хаягдлын түр хуримтлуулж байна.




Зураг 13. Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилан ялгах хогийн савны харагдах байдал

## 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Элгэдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээн, ногоон байгууламж бий болгох | Орчны тохижилтыг сайжруулан, 1234.9 $м^2$ талбайд ногоон байгууламж хийх | Улиас | Ширхэг | 26 | 5000 | 130.000 | 2021-2025 оны хооронд ногоон байгууламжийг сайжруулах ажилд нийт 48 нэр төрлийн зуун наст болон гацуур мод тарьж ургуулсан байна.<br><br>2021-2025 онуудад бутлаг мод 77 нэр төрлөөр, жижиг бутлаг мод 102 тус тус  тарьж ургуулсан байна.<br><br>Баянзүрх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах улсын нэгдсэн 2-р эмнэлгийн хажуу талын нийтийн эзэмшлийн талбайн бичил цэцэрлэгт хүрээлэнд нарс, гүйлс, монос мод тарьж, зүлэгжүүлэн тохижуулах ажлыг 2025.09.05 өдрөөс 2025.10.05-ны өдөр хүртэл манай “Эвт чулуу” ХХК болон бусад өөр 18 аж ахуйн нэгжүүдтэй хамтран хөрөнгө гарган ойн мэргэжлийн байгууллага болох “Тэгш газар” ХХК-р хийж гүйцэтгүүлсэн болно. |
| | | Хайлаас | Ширхэг | 25 | 4500 | 112,500 | |
| | | Нийт | | | | 242.500 | |
| Шаардагдах техник, хэрэгсэл | | Хүрз | ш | - | - | | |
| | | Ухуур | ш | | - | - | |
| | | Усалгааны сав | ш | - | - | - | |
| | | Усны шланк | м | - | - | - | |
| | | Модны хайч | ш | - | - | 50.000 | |
| | | Тайралт хийх хайч | - | - | - | 30.000 | |
| | | Хор шүршигч | | | | 25.000 | |
| | | Бордоо | 25 кг | 50 уут | 25000 | 1.250.000 | |
| | | Хар шороо | 1 машин | | - | 340.000 | |
| Ногоон байгууламж байгуулах зардал | | Арготехникийн ажиллагаа | | | | 1.000,000 | |
| | | Суулгацыг тээвэрлэх зардал | | | | 250,000 | |
| | | Ажилчдын хөлс | | | | - | |
| Арчилгаа, тордлогоо | Ногоон байгууламжийн усалгаа тайралт, хэлбэржүүлэлт хийх | Төслийн талбайд | | | | 300.000 | |
| ***Нийт дүн 10,987,500*** | | | | | | | |

### 6.1. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт, тарималжуулалтын ажлын биелэлт

2021-2025 оны хооронд ногоон байгууламжийг сайжруулах ажилд нийт 48 нэр төрлийн зуун наст болон гацуур мод тарьж ургуулсан бөгөөд мөн бутлаг мод 77 нэр төрлөөр, жижиг бутлаг мод 102 ширхгийг тус тус тарьж ургуулсан байна.




Зураг 14. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт, тарималжуулалтын ажил хийсэн байдал

Баянзүрх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах улсын нэгдсэн 2-р эмнэлгийн хажуу талын нийтийн эзэмшлийн талбайн бичил цэцэрлэгт хүрээлэнд нарс, гүйлс, монос мод тарьж, зүлэгжүүлэн тохижуулах ажлыг 2025.09.05 өдрөөс 2025.10.05-ны өдөр хүртэл манай “Эвт чулуу” ХХК болон бусад өөр 18 аж ахуйн нэгжүүдтэй хамтран хөрөнгө гарган ойн мэргэжлийн байгууллага болох “Тэгш газар” ХХК-р хийж гүйцэтгүүлсэн болно.




Зураг 15. Тарималжуулалт ажил хийсэн байршил

Нийтийн эзэмшлийн 866 мкв талбайг зүлэгжүүлж, 45 нарс, 150 гүйлс, 75 монос нийтдээ 270 мод тарих ажлыг хийж гүйцэтгүүлсэн байна.



Зураг 16. Ногоон байгууламж тарималжуулалтын ажлын өмнө












Зураг 17. Ногоон байгууламж тарималжуулалтын ажил хийж гүйцэтгэж дууссан байдал






Зураг 18. Хөрөнгө гаргасан аж ахуйн нэгжийн нэрс



ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР

"ТЭГШ ГАЗАР" ХХК

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛЫН ХӨРӨНГӨӨР НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 3 ДУГААР ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ УЛСЫН НЭГДСЭН 2 ДУГААР ЭМНЭЛГИЙН ХАЖУУ ТАЛЫН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙД НАРС, ГҮЙЛС, МОНОС МОД СУУЛГАЖ, ЗҮЛЭГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот

2025 он

ТЭГШ ГАЗАР ХХК 2025



ТАЙЛАН

| Хөрөнгө гаргасан аж ахуйн нэгжийн нэрс | | | |
|---|---|---|---|
| 1 | "Багануур" ХК | 10 | "Лакширикристал" ХХК |
| 2 | "Эвтчулуу" ХХК | 11 | "Цэцэгэ импекс" ХХК /ХУД/ |
| 3 | "Монфрукт" ХХК | 12 | "Шар монгол" ХХК |
| 4 | "Сэрүүн сэлбэ" ХХК | 13 | "Амьдралын илч" ХХК |
| 5 | "Ката" ХХК | 14 | "Минжийн хангай төгөл" ХХК |
| 6 | "Цэцэгэ импекс" ХХК | 15 | "Сүр сүлд" ХХК |
| 7 | "Мөнхсонор трейд" ХХК | 16 | "Мандах булаг" ХХК |
| 8 | "Жи Эс Эн Ди" ХХК | 17 | "Кенже" ХХК |
| 9 | "Сүмбэр хунтан" ХХК | 18 | "Шинэ тоосго" ХХК |

ХҮЛЭЭН АВСАН:
ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НБОГ-ЫН ХБОАХХ-ИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.БАТЗОЛБОО

НБОГ-ЫН ХБОАХХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН С.СҮХЦООЖ

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:
ГҮЙЦЭТГЭГЧ:

"ТЭГШ ГАЗАР" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.АЛТАНЦЭЦЭГ

"ТЭГШ ГАЗАР" ХХК-ИЙН ТАЛБАЙН ИНЖЕНЕР Б.ЭНХТҮВШИН

ТЭГШ ГАЗАР ХХК 2025

Зураг 19. Баянзүрх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах улсын нэгдсэн 2-р эмнэлгийн хажуу талын нийтийн эзэмшлийн талбайн бичил цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж, зүлэгжүүлэн тохижуулах ажлын тайлан

## 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

<table>
<tr><th>Хог хаягдлын ангилал</th><th>Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</th><th>Арга хэмжээний цар, хэмжээ</th><th>Тоо хэмжээ</th><th>Нэгж зардал (.төг)</th><th>Нийт зардал (.төг)</th><th>Биелэлт</th></tr>
<tr><td rowspan="4">Ахуйн болон химийн аюултай хатуу хог хаягдал</td><td>Ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг зайлуулах гэрээг дүүргийн ТҮК-тай байгуулж нэгдсэн хогийн цэгт тогтмол зөөвөрлөх</td><td>Хатуу хог хаягдал</td><td>Жилд 1 удаа</td><td colspan="2">Үйл ажиллагааны зардалд тусгах</td><td>“Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-тэй хийсэн 2025.02.14-ны өдрийн №24/27 дугаар бүхий хог, хаягдал хаях гэрээний дагуу зайлуулж байна.</td></tr>
<tr><td>Хатуу хог хаягдлыг ангилан ялгах менежментийг сайжруулах, ажилчдад сургалт зохион байгуулах</td><td>Төслийн хүрээнд</td><td>Жилд нэг уда</td><td colspan="2">200.000</td><td></td></tr>
<tr><td>Химийн бодисын сав баглаа боодлыг аюулгүй зайлуулах, устгах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах</td><td>Төслийн хүрээнд</td><td>Төсөл хэрэгжих бүх үе шатанд</td><td colspan="2">Гэрээнд заасан үнийн дүнгийн дагуу төлөх. Үйл ажиллагааны зардалд тусгах</td><td rowspan="2">“Хай би ойл” ХХК-тай хийсэн 2025.08.14-ны өдрийн №АХХ-25 дугаартай аюултай хог хаягдал хүлээн авч, тээвэрлэх гэрээ</td></tr>
<tr><td>Химийн бодисын сав баглаа боодлыг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн мэдээллийн сан, бүртгэл үүсгэх</td><td>Төслийн хүрээнд</td><td>Төсөл хэрэгжих бүх үе шатанд</td><td colspan="2">-</td></tr>
<tr><td>Хог хаягдал хуримтлагдах</td><td>Төслийн талбай орчныг бохирдуулахаас сэргийлж, холбогдох байгууллагатай хамтран ойр орчимд тогтмол цэвэрлэгээ хийж байх</td><td>Ойр орчмын 50 метр газарт</td><td>Улиралд нэг удаа</td><td colspan="2">240.000</td><td>Төслийн талбай орчныг бохирдуулахаас сэргийлж ойр орчимд тогтмол цэвэрлэгээ хийж гүйцэтгэж байна.</td></tr>
<tr><td>Удаан задардаг хатуу хог хаягдал үүсэх</td><td>Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх</td><td>Төслийн хүрээнд</td><td>Тухай бүрт нь</td><td colspan="2">Зардал тусгах шаардлагагүй.</td><td>Үйлдвэрийн талбайд хог хаягдлыг ангилан ялгах хуримтлуулах зориулалтын цэгт хог хаягдлыг түр хуримтлуулж холбогдох байгууллагад шилжүүлж байна.</td></tr>
<tr><td>Ялаа шавж үржих, өвчин гарах</td><td>Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх</td><td>Хатуу хог хаягдлын цэгт</td><td>Улирал бүр 1 удаа</td><td colspan="2">100.000</td><td>Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг сар тутам тогтмол цэвэрлээг хийж байна.<br>Мөн “Улаанбаатар ариутгал” ХХК-р Халдваргүйтгэл, ахуйн хортон шавж, мэрэгчийн тандалт, устгалын ажлыг хийлгэсэн байна.</td></tr>
<tr><td colspan="7">540.000</td></tr>
</table>

**Ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг зайлуулах гэрээг дүүргийн ТҮК-тай байгуулж нэгдсэн хогийн цэгт тогтмол зөөвөрлөх:** “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-тэй хийсэн 2024.03.04-ны өдрийн №24/23 дугаартай гэрээ болон 2025.02.14-ны өдрийн №24/27 дугаартай гэрээний дагуу зайлуулж байна.



ХОГ, ХАЯГДАЛ ХАЯХ 24/34 ТООТ ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ГЭРЭЭ

№ 24/27

2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр — Улаанбаатар хот

Нэг талаас "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ /цаашид "А" гэх/, нөгөө талаас "Эвт чулуу" ХХК РД:5053986 /цаашид "Б" гэх/ түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Амгаланбат /цаашид "Б" гэх/ нар харилцан тохиролцож, А болон Б нарын хооронд /цаашид хамтад нь Талууд гэх/ 2024 оны 03 дугээр сарын 04-ний өдөр байгуулсан 24/23 тоот "Хог хаягдал хаях гэрээ" /цаашид Үндсэн гэрээ гэх/-ний 6 дугаар зүйлийн 6.1 дахь хэсэг болон НИТХТ-ийн 2016 оны 14 дүгээр тогтоолоор баталсан Хот тохижилтын газрын дүрэм, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 24/27 дугаар тогтоолоор батлагдсан "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" тогтоолыг тус тус үндэслэн талууд харилцан тохиролцож энэхүү нэмэлт гэрээг байгуулав.

**Нэг.** Энэхүү нэмэлт гэрээнд 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан автомашин автомашинууд дээр хийсэн хог хаягдал хаях 24/23 тоот гэрээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүргэлт сунгав.

Хоёр.Үндсэн гэрээний 2 дугаар зүйлийн 2.1 дахь хэсэгт заасан нэг тонн хог хаягдлын үнэлгээ **6364 /зургаан мянга гурван зуун жаран дөрөв/** төгрөг бөгөөд НӨАТ шингэсэн үнэ болгож нэмэлт өөрчлөлт оруулав.

**Гурав.** Энэхүү нэмэлт гэрээ нь Үндсэн гэрээний салшгүй хэсэг болно. Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй бусад бүх харилцааг Үндсэн гэрээгээр зохицуулна.

**Дөрөв.** Энэхүү нэмэлт гэрээнд талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно. Энэхүү нэмэлт гэрээг хууль эрх зүйн хүрээнд адил хүчинтэй 3 хувь үйлдэв.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

А талыг төлөөлж:

"ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА — Б.МӨНХЦЭЦЭГ

ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Ц.ОЧИРОО

ТООЦООНЫ НЯГТЛАН БОДОГЧ — Ж.ДААРИЙМАА

Хаяг: Баянзүрх дүүргийн 1 хороо, Залуусын гудамж, Сансар тунель дээрх өөрийн байр

Утас: 11- 453501

Б талыг төлөөлж:

"ЭВТ ЧУЛУУ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ — Б.АМГАЛАНБАТ

Хаяг: Баянзүрх дүүргийн 41-р хороо, 63В-р байр, 301 тоот

Утас: 77168383, 94293993



ХОГ ХАЯГДАЛ ХАЯХ ГЭРЭЭ

2024 оны 03 дугаар сарын 04 — №24/23 — Улаанбаатар хот

